



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/656

Хэрлэн сум


Хэрлэн сумын Наймдугаар цэцэрлэгийн  
тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хэрлэн сумын наймдугаар цэцэрлэгийн барилгыг өргөтгөсөнтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заасан “4” бүлэг байсныг “5”, Мэргэжлийн зэрэг, багшлах эрхтэй багшийн хувь “40/80” байсныг “50/100”, барилгын хүчин чадал “75” байсныг “125” болгон өөрчлөлт оруулсугай.

2.Өөрчлөлтийн талаарх мэдээллийг тус цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тэмдэглэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ